



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/60

Арвайхээр сум

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/561 дүгээр захирамжаар батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай" хөтөлбөрийн 2.1.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын Соёл, урлагийн хэлтсийн дарга Лозвойн Пүрэвлхамын соёл, судлалын докторын зэрэг хамгаалах сургалтын төлбөрт 1,000,000 (нэг сая) төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

8223 11 0131